

2025 он

В. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээ, дэд бүтцийн төслийн тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

БАТЛАВ. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга:

_____ / _____ /

эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга)

_____ / _____ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Страто ХХК-ний захирал А.Баттүшиг / _____ /

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМ
"СТРАТО" ХХК-НИЙ "НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР"
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5990769/

Хянасан: Говьсүмбэр аймгийн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн газрын хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн: _____ / _____ /

ГАРЧИГ


1. Төслийн ерөнхий мэдээлэл
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн гол зорилго
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
4. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайлан
8. Тайлангийн хавсралт материалууд

1.Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	Нүүрс угаах үйлдвэр, нүүрс ачиж буулгах талбай
Төсөл хэрэгжүүлэгч:	“Страто” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011566018
Регистрийн дугаар:	5990769
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 11/1, Болор төв, 209 тоот 99118240, 88094598
Ашиглах талбай:	Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2-р багийн нутагт төмөр замын 21-р зөрлөгийн баруун урд талд 122,5 га талбайд хэрэгжих ба төслийн талбай нь Шивээ-Овоогийн нүүрсний уурхайгаас 3.5 км, Шивээ говь сумаас 11.5 км, Төмөр замын 21-р зөрлөгөөс 1.5 км, Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай автозамаас 8 км зайд оршино.

2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн гол зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (БОМТ) тусгагдсаны дагуу хэрэгжүүлсэн тухайгаа тайлагнах үндсэн зорилготой баримт юм.



3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

- Дулааны улиралд агаар мандал дахь тоосжилтыг багасгах зорилгоор усны машинаар гүний худгийн усыг зөөж, шүрших ажлыг хийж хэвшүүлсэн.
- Агаарын хуурайшилт өндөр хавар намрын улиралд талбайд ил гал гарахаас сэргийлэн талбайд нүүрсний овоолго байгаа тохиолдолд тогтсон цаг өдрөөр усны машинаар ус цацах арга хэмжээг байнга хэрэгжүүлсэн.
- Талбайд байгаа том оврын машин болон техник механизмуудын хөдөлгүүрийг унтрааж ажиллах ээлжээ хүлээх шаардлагыг нийт ажилчид болон операторуудад тавьж ажилласан.
- Ундны усны эрүүл ахуйг хангах зорилгоор ажилчдын унд хоолондоо хэрэглэх усыг худаас 200 литрээр зөөвөрлөн худалдан авч хэрэглэдэг.
- Ахуйн хэрэгцээний болон орчны тоосжилтыг дарах зорилгоор хэрэглэдэг гүний худгийн усны тоног төхөөрөмж болон усны тоолуурыг хянаж шаардлагатай үед сольж акт үйлдэн баталгаажуулан ашигласан.
- Гүний усны худгийн тоолуурын заалтаар ус ашиглалтын төлбөрөө төлж байгаа.
- Стандартын шаардлага хангасан түлш хэрэглэж, техник механизмын үйлчилгээ үзлэгийг тогтсон цаг бүрд хийлгэж, эвдрэл гэмтэлгүй техникээр үйл ажиллагаагаа явуулан агаар хөрсөнд нөлөөлөх механик бохирдлоос сэргийлэн ажиллаж байгаа.
- Дотоод тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох тэмдэг, тэмдэглэгээ байршуулан, Үйл ажиллагааны туршид Үйлдвэрээс дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоосон.
- Техник тоног төхөөрөмжийн аюулгүйн ажиллагааг ханган эвдрэл гэмтлийг тухай бүрд илрүүлэн, зориулалтын бетон шалтай грашт засварлах болон байршуулж байгаа.

4.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбай орчимд аливаа түүх соёлын өв, дурсгалт олдвор хэмжигдээгүй бөгөөд хэрвээ барилгажилтын үеийн газар шорооны үед олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр үйл ажиллагааг түр зогсоох шаардлагатай. Төсөл хэрэгжих талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч барилга, газар шорооны ажлын явцад соёлын өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс үйлдвэрийн үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон

тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв үйлдвэрийн болон барилгын үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилтанд ажилчдыг хамруулж эхэлсэн.
- Ажилчдад хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгслээр хангаж байгаа.
- Анхны тусламжийн хайрцгийг ажилчидын байранд байршуулан түүнийг яаралтай үед хэрхэн хэрэглэх заавар өгч танилцуулсан.
- Ил гарч болзошгүй хэсэгт галын аюулаас сэргийлэх хэрэгсэл байршуулан, ил гал гаргах болон тамхи татахыг хориглосон самбар байршуулан шаардлага тавьж ажиллаж байгаа.

6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

- Хөрс болон орчны бохирдлыг багасгах зорилгоор ил задгай бие засах газрыг хааж бие даасан бохирын системтэй ариун цэврийн өрөөнүүдийг хэрэглэж заншсан.
- Талбайн ажилд хэрэглэдэг техник болон механизмийн тос тосолгооны бодис түүний хаягдалыг хөрсөнд нэвчүүлэхээргүй орчинд тусгайлсан саванд агуулдаг болсон.
- Ангилсан хогийн савыг байршуулан зориулалтын дагуу хэрэглэж заншсан.

7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайлан

- Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулан мөрдөж эхэлсэн.
- Байгаль орчин хариуцсан ажилтан томилон, сөрөг нөлөөг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шаардлага тавих ажлыг хийлгэхээр даалган ажиллаж байна.

- Сумын засаг даргын газрын байгаль орчин хариуцсан мэргэжилтэнтэй төслийн талбайгаас хог хаягдал зөөлгөх гэрээг байгуулан хамтран ажиллаж байгаа.
- Сумын газар нутагт манай байгууллагаас нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр хийгддэг хог хаягдал, лаг шавар, үхсэн малын сэг зэм, зам дээр бүрхсэн цасан бүрхүүл зэргийг машин механизмаар түрж, зөөвөрлөн хаяж, шороон замын тоосжилтыг усны машинаар шүршин дарах зэрэг үйл ажиллагааг хийж байгаа.

8. Тайлангийн хавсралт материалууд

Машин болон механизмын граш



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Тос тосолгоо болон нефтийн бүтээгдэхүүний тусгаарлалт





Түлшний нийлүүлэлт




“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Гүний худгийн усны тоолуур болон худагийн байр



Ариун цэврийн өрөөнүүд



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Бохир соруулалт



Орчны аюулгүй байдлын үйл ажиллагаа



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Үйлдвэрийн талбай болон сумын нутаг дэвсгэрт усалгааны ажил



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Ажилчдын аюулгүйн ажиллагааны хувцас хэрэглэл



Галын аюулгүй байдал түүнийг хангах хэрэгсэл



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Үйлдвэрийн талбайн болон сумын нутаг дэвсгэрт хог болон амьтны сэг цэвэрлэх ажил



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



“Страто” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд орших “Нүүрс баяжуулах үйлдвэрийн” 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Цас түрэх цэвэрлэх ажил



Хог хаягдлыг ангилан хаях сав





ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 25

Чойр

Дугаар, он /№ :
Сорьц ирүүлсэн байгууллагын нэр, хаяг, утас : "Страто ХХК"
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Код-1
Сорьц авсан аймаг, сум, газрын нэр : Говьсүмбэр аймаг, Шивээговь сум
Сорьц авсан төрөл, хэмжээ, тоо : Тоос 24 цаг
Сорьц авсан огноо : 2025.11.04
Лабораторид ирсэн огноо : 2025.11.04
Сорилтын арга, аргачлал : MNS 0017-2-5-12:2021
: MNS 0017-2-5-11:2021
: MNS4048-88
Дээжийн тодорхойлсон үзүүлэлт : Хүхэрлэг хий, азотын давхар
исэл, нийт тоос
Хэвлэсэн огноо : 2025.11.10

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд, мг/м ³	
		Азотын давхар исэл (NO ₂)	Хүхэрлэг хий (SO ₂)
1	Ажлын талбай	0.008	0.013
2	Кемп	0.009	0.012
MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж		0.200	0.450

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд		
		Нийт тоос, мг/м ³		
		Дундаж	Хамгийн их	Хамгийн бага
1	Ажлын талбай	0.045	0.429	0.016
MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж		0.500	-	-

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Страто ХХК-ний орчмоос агаарын дээж авч шинжилгээ хийхэд MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер
Шинжилгээ боловсруулсан БОШЛ-ийн чанарын инженер
Хянасан: Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н. Марал-Эрдэнэ/
Оюунгэрэл/
Ш. Мөнгөнцэцэг/



Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хамаарна.

9014537 СТА0500 4. 204466



МИКРО ВОРЛД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ХОС ДАЛЬ ЦЕНТР 7 давхар 703-тоот,
Хан-Уул дүүргийн, 3 дугаар хороо, Улаанбаатар хот
Утас: +976 88988611
E-мэйл: microworld222@gmail.com



СОРИЛТЫН ТАЙЛАН /TEST REPORTS/

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргагч:
/The name of customer's request for analysis/

СТРАТО ХХК

Сорьцын тодорхойлолт: /Sample specification/	Хөрс	
Шинжилгээ /Analysis/	Эхэлсэн огноо /Date of receipt/	2025.10.22 13:06
	Дууссан огноо /Date of completion/	2025.11.03 10:00
	Хэвлэсэн огноо /Date of issue of the report/	2025.11.03

Лабораторийн дугаар /Laboratory ID number/	Сорьцын нэр /Name of sample/	Сорьцын тоо, хэмжээ /Quantity of the sample/
W2355	Кемп хэсэг	0.5 кг
W2356	Хогийн цэгний хэсэг	0.5 кг
W2357	Ачилт буулгалтын талбай	0.5 кг
W2358	Хоосон талбай	0.5 кг

Сорилтын аргын тэмдэглэгээ /Method of analysis/	Сорилтын үзүүлэлтүүд, хэмжих нэгж /Test parameters, unit/	Шаардлага /Specification/	Сорилтын дүн /Test results/			
		MNS 3297:2019 Лавлах хэмжээ /Reference/	W2355	W2356	W2357	W2358
MNS 6341:2012	Бичил биетний тоо /1гр-д/	-	7*10 ⁶	1*10 ⁶	5*10 ⁶	6*10 ⁶
MNS 6341:2012	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч /Salmonella spp/ /1гр-д/	Илрэх ёсгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
MNS ISO 5367:2004	Колититр /1гр-д/	≥0.1	0.0001	0.1	0.001	0.0001
MNS 6341:2012	Cl.perfringens титр /1гр-д/	≥0.1	0.001	0.001	0.001	0.001

ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН

/Monitored and Approved by/

МИКРО ВОРЛД СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЭРХЭЛЭГЧ:

/Head of Research & Analysis Center/

О.БҮДХАНД

/Budkhand.O/

ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

/Analyzed by/

ШИНЖЭЭЧИЙН КОД:

/Code for Research Specialist/


MW-25-T2

БАТЛАВ.
“СТРАТО” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



А.БАТТУШИГ

БАТЛАВ.
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГА



Ч.СУГАРМАА

ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2025.08.29

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Нэг талаас Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэний үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баттуул нөгөө талаас 5990769 тоот регистрын дугаартай, Шивээговь сумын 2-р багийн нутаг дэвсгэрт байрлах, “Страто” ХХК-ны Гүйцэтгэх захирал А.Баттүшигцаашид Үйлчлүүлэгч гэх\ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээ нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцсон болно.

Хоёр. Сумын Засаг даргын Тамгын газрын хүлээх эрх, үүрэг

2.1 Төсөвт байгууллага, хувийн хэвшил, аж ахуй нэгж, үйлдвэр үйлчилгээний газруудтай үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог эрхлэх үйл ажиллагаанаас хамаарч нормативыг мөрдүүлнэ.

2.2 Захиалагч байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нормативын дагуу жилд нэг удаа, энгийн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх зардлыг сар бүр, сумын төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3 Захиалагч байгууллагын хог хаягдлыг зайлуулах үйл ажиллагааны хугацааг гэрээнд тусгана.

2.4 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Сумын ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолын нормативыг дагаж мөрдөнө.

2.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавина.

2.6 Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх хог хаягдал үүсгэсэн байгууллагад шаардлага тавих шат дараалсан арга хэмжээ авна.

Гурав. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

3.1 . Үйлчлүүлэгч тал “Хог хаягдлын тухай” хуулийг мөрдөж ажиллана.

3.2 . Үйлчлүүлэгч тал хог хаягдлаа ачиж зориулалтын хогийн цэгт хаяж шаардлагатай тохиолдолд булж устгах үүрэгтэй.

3.3 . Үйлчлүүлэгч тал өөрийн байгууллагаас 50 метрийн зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар

бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг байнга хийж гарах хог хаягдлыг цэвэрлүүлж байна.

3.4. Үйлчлүүлэгч тал нь гэрээний 3.2-д заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААН, АБ, иргэнд учирсан хохирлыг Үйлчлүүлэгч тал бүрэн хариуцна.

3.5 Хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог хаягдлын төвлөрсөн цэгт орох гарах замыг чөлөөтэй нэвтрэх боломжийг хязгаарлахгүй байх, хаагдсан замыг чөлөөлөх үүрэгтэй.

3.6 Өөрийн эзэмшил, өмчлөлийн барилгаа барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар ЗДТГ-т урьдчилан мэдэгдэж, гэрээ байгуулан зохих төлбөрийг төлнө.

3.7 Хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.

3.8 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх. Хаясан тохиолдолд цэвэрлэгээ үйлчилгээг Үйлчлүүлэгч тал бүрэн хариуцна.

3.9 Хог хаягдлыг ангилан ялгах талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.

3.10 Үйлчлүүлэгч тал хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.

3.11 Хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

4.1 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 20-нд орон нутгийн орлогын **Төрийн сан банк 100220300947** тоот дансанд тушаана.

4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь Сумын ИТХ-аас тогтоосон тарифын дагуу сард 80.000 /наян мянга/ төгрөг, жилд 960.000 /есөн зуун жаран мянга/ төгрөг байна.

4.3 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт болон зах зээлийн үнийн интервалаас хамаарч үйлчилгээний тарифт өөрчлөлт оруулж болно.

4.4 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа тээвэрлэгч тээвэрлэнэ.

4.5 Хог тээвэрлэлтийн төлбөрийг Үйлчлүүлэгч тал гэрээний 3.6-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0.5 хувийн алданги төлнө.

Тав. Хамтран хүлээх хариуцлага

5.1 Талууд энэхүү гэрээ зөрчөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.

5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

5.3 Сумаас зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдаж ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно.

Зургаа. Бусад

6.1 Энэхүү гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээг 2 хувь үйлдэж, талууд нэг нэг хувийг авна.

6.3 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:
ШИВЭЭГОВЬ СУМЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭНИЙ ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Д.БАТТУУЛ

УТАСНЫ ДУГААР: 95953629

“СТРАТО” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



А.БАТТУШИГ

УТАСНЫ ДУГААР: 88094598



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

Ногоон хөгжлийн төв, Залуучуудын өргөн чөлөө II-208,
2 дугаар баг, Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42017

Утас/Факс: (976) 7054 3063,

Цахим шуудан: baigaliorchin.gsa@baigal.gs.gov.mn,

Цахим хуудас: www.baigal.gs.gov.mn

2025.10.31 № 278

танай _____-ны № _____-г

**“СТРАТО” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ А.БАТТУШИГ ТАНАА**


Танай компаниас ирүүлсэн албан хүсэлт болон холбогдох бусад материалыг үндэслэн Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу Шивээговь суманд хэрэгжих “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн 2025 оны Ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж хүргүүлэв.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтын дагуу Шивээговь сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллана уу.

Хувийг Шивээговь сумын Засаг даргад

Хавсралт хуудас

ДАРГА



Г.ХОНГОР

4225030479

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
2025 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025.10.27

Дугаар 2025/13

Говьсүмбэр аймаг

1. Аж ахуйн нэгж, байгууллага, захирлын нэр, хаяг, утас, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар: "Страто" ХХК, гүйцэтгэх захирал А.Баттүшиг, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө 11/1, Болор төв, 209 тоот. Утас: 99118240, улсын бүртгэлийн дугаар: 9019089102, регистрийн дугаар: 5990769.

2. Төслийн байршил, харьяалагдах сав газар: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, 2 дугаар баг, 21 дүгээр зөрлөгийн баруун урд талд байрлах бөгөөд Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт харьяалагдана. /Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын 2024 оны 01 сарын 31-ний өдрийн А/26 тоот шийдвэрээр үйлдвэрлэлийн зориулалтаар 122.5 га газрыг 5 жилийн хугацаатайгаар эзэмшсэн./

3. Төсөл хэрэгжүүлэгч:

"Страто" ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн хэмжээ, координат /X,Y/:

Талбайн координат: x= 5118326.38 y= 310396.57
5118243.41 310426.80
5118243.41 310426.80
5118236.93 310655.04
5118091.58 310812.32
5116771.65 311297.73
5116514.12 310611.23
5118193.70 310019.18
5118223.68 310114.70

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:

"Нүүрс баяжуулах үйлдвэр".

6. Үйлдвэрийн техник, технологи, ажиллах горим, хүчин чадал:

Тус үйлдвэр нь гравитаци, флотацийн аргаар нүүрс баяжуулах бөгөөд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд технологид үндэслэсэн ST12 маркын гурван шатны нүүрс баяжуулах, 1 шатны хөвүүлэн баяжуулах иж бүрэн тоног төхөөрөмжийг суурилуулсан. Нүүрс баяжуулах үндсэн тоног төхөөрөмжүүд нь тэжээгч бутлуур, туузан конвейрүүд, булт бутлуур, тунаах машин, шламгүйжүүлэх шигшүүр, хяналтын шигшүүр, нүүрс усгүйжүүлэн хатаагч, хөвүүлэн баяжуулах машин, хаягдлын өтгөрүүлэгч, баяжмалын өтгөрүүлэгч болон өндөр даралтын фильтр пресс зэрэг байна. Үйлдвэрийн нийт хүчин чадал 1000.0 мян.тн/ жил.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

Нүүрс баяжуулах үйлдвэр нь цагт 144.69 тн/цаг, сард 83333 тн/сар, жилд 1000.0 мян.тн/жил нүүрс угаан баяжуулах хүчин чадалтай.

8. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ:

"Страто" ХХК 2025 онд нүүрс угаан баяжуулах үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд ажилчдын ахуйн хэрэглээ, ногоон байгууламжийн усалгаа, тоосжилт дарах зориулалтаар ус ашиглана. Дээрх усны хэрэглээг өөрийн эзэмшлийн талбайд байрлах гүний худгаас ашиглана. Ажилчдын ундны усыг зөөврөөр авч ашиглана. /Тус компаниас ирүүлсэн 2025 оны ус ашиглах төлөвлөгөөг үндэслэв./

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/:

Гүний худаг 1, ундарга 1л/сек. Худгийн координат: Уртраг: 108° 32' 28.68"

Өргөрөг: 46° 11' 28.97"

Гүний худаг 2, ундарга 30л/сек. Худгийн координат: Уртраг: 108° 32' 24.58"

Өргөрөг: 46° 11' 26.80"

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

Үйлдвэрт байрлах гүний худгийг ашиглахгүй бөгөөд төслийн талбайд байрлах худгаас ус ашиглана. Тус худгийн цооногийн гүн 60 метр, ундарга 1 л/сек. Худагт LXSG-25 загварын тоолуурийг 2025 оны 04 сарын 25-ны өдөр суурилуулсан. Тоолуурын баталгаажуулалтын хугацаа 2027 оны 04 сарын 11-ний өдөр дуусна. Дүгнэлт гаргах үеийн тоолуурын заалт 0001м³.

11. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл:

“Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг “Грийн солюшн консалтинг” ХХК 2024 онд гүйцэтгэж батлуулсан.

12. Онцгой нөхцөл:

Худгийн тоолуурын ашиглалт, чанар, баталгаажуулалтад хяналт тавьж бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах.

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ийг үндэслэн тооцоход:

Ажилчдын унд, ахуйн хэрэгцээнд:

$7\text{хүн} \times 150\text{л/хон} \times 256\text{хон} = 268.8\text{м}^3/\text{жил}$ – Жилд ахуйн хэрэгцээнд ашиглах усны хэмжээ

Ногоон байгууламжийн усалгаанд:

Өөрийн эзэмшлийн талбайд тарьсан 1500 ширхэг модыг сард дунджаар 4 удаа усална гэж тооцоход 7 сарын хугацаанд нийт 28 удаа усална гэж тооцов. /Тус компаний 2025 оны ус ашиглах төлөвлөгөөг үндэслэв/

$1500\text{ш} \times 40\text{л/хон} \times 28\text{удаа} = 1680.0\text{м}^3/\text{жил}$

Тоосжилт дарахад:

$20000\text{м}^2 \times 2\text{л} \times 60\text{хон} = 2400.0\text{м}^3/\text{жил}$ – Жилд тоосжилт дарах зориулалтаар ашиглах усны хэмжээ

Нийт $268.8.0\text{м}^3 + 1680.0\text{м}^3 + 2400.0\text{м}^3 = 4348.8\text{м}^3/\text{жил}$ – 2025 онд ажилчдын ахуйн хэрэгцээ болон ногоон байгууламжийн усалгаа, тоосжилт дарах зориулалтаар ашиглах усны нийт хэмжээ

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдлаар тооцоход:

Ажилчдын ахуйн хэрэгцээнд ашиглах $268.8\text{м}^3/\text{жил}$ усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

1м^3 усны нөөц ашигласны төлбөр: $3700\text{төг}/\text{м}^3 \times 0.15 \times 0.16 = 88.8\text{төг}/\text{м}^3$

- $3700 \text{ төг}/\text{м}^3$ – Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

- (15%) – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 10-д заасан газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь;

- (0.16) – Бусад ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усанд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$268.8\text{м}^3/\text{жил} \times 88.8\text{төг}/\text{м}^3 = 23,869 \text{ төгрөг}$

/Хорин гурван мянга найман зуун жаран ес/

Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах 1680.0м^3 усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

1м^3 усны нөөц ашигласны төлбөр: $3700\text{төг}/\text{м}^3 \times 0.15 \times 0.2 = 111\text{төг}/\text{м}^3$

- $3700 \text{ төг}/\text{м}^3$ – Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

- (15%) – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 10-д заасан газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;

- (0.2) – Ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$1680.0\text{м}^3/\text{жил} \times 111\text{төг}/\text{м}^3 = 186,480 \text{ төгрөг}$

/Нэг зуун наян зургаан мянга дөрвөн зуун ная/

Талбайн тоосжилт дарах зориулалтаар ашиглах 1680.0м^3 усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолыг үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

1м^3 усны нөөц ашигласны төлбөр: $3700\text{төг}/\text{м}^3 \times 0.2 \times 0.25 = 185\text{төг}/\text{м}^3$

- $3700 \text{ төг}/\text{м}^3$ – Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

- (20%) – Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 4-т заасан газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;

- (0.25) – Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт автозамын зориулалтаар газрын доорх ус ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

2400.0м³/жил х 185төг = 444,000 төгрөг

/Дөрвөн зуун дөчин дөрвөн мянга/

Нийт 23869 + 186480 + 444000 = 654,349 төгрөг

/Зургаан зуун тавин дөрвөн мянга гурван зуун дөчин ес/

Усны нөөц ашигласны төлбөрийг Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Төрийн сан банкны **100220000944** тоот дансанд тухайн оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор төвлөрүүлэх.

15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:

Усны тоолуурын ашиглалтад хяналт тавьж усны алдагдал гаргахгүй байх, усыг ашиглах боломжит нөөцийн хэмжээнд зохистой ашиглах.

16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах.
- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасны дагуу эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх
- Хаягдал усны дүгнэлтийг Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаагаар гаргуулах
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/156 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ыг мөрдөж ажиллах
- Худгийн тоолуурын ашиглалт, чанар, баталгаажуулалтад хяналт тавьж бүрэн бүтэн байдлыг хангах
- Цооногийн түвшин, чанарт байнга хяналт тавих, усыг хэмнэлттэй ашиглах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх.
- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах.
- Мөн хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, тайланг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.
- Газрын доорхи уснаас шууд ашиглах усны хэмжээг ус хэрэглээний нормоор тооцсон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.
- Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан /ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ/-г 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны газарт ирүүлэх. Тухайн онд үйл ажиллагаа явуулахаас өмнөх болон ус ашиглалтын тайлан гаргах үеийн тоолуурын заалтыг авч баталгаажуулах.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, УСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН**



Н.НАМУУНЦЭЦЭГ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, Нэрт баг,
Шивээговь сум, Говьсүмбэр аймаг, 42030
Утас/Факс: (976) 7054 6204,
Цахим хуудас: www.shiveegovi.gs.gov.mn

2025.04.29 № 01/225

танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Бэхт баг, 21 дүгээр өртөөний баруун урд талд байрлах “Страто” ХХК нь 2020-2025 онд нүүрс боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд өөрсдийн эзэмшлийн талбайг ачилт, буулгалтын зориулалтаар ашиглаж байгаа болно.

Хувийг: “Страто” ХХК-д хүргүүлэв.



Ч.СУГАРМАА

